

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Авто үйлчилгээ - Ангилал, Ерөнхий шаардлага	MNS 5025 :
Auto service - Classification, General requirements	MNS 5025 :

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь авто үйлчилгээг зохион байгуулах нийтлэг шаардлага, журам тогтооход төр, захиргааны болон бусад байгууллагаас хяналт тавих, ажил үйлчилгээнд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2. Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэхүү стандарт нь авто үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон ажил үйлчилгээнд тавих шаардлагыг тогтооход хамаарна.

Энэхүү стандартыг авто үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон түүнд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан мөрдөнө.

3. Норматив ишлэл

3.1 Энэхүү стандартыг боловсруулахад ашигласан дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас иш татаж хэрэглэнэ. Үүнд:

- MNS4601, Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүн, техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо, тодорхойлолт
- MNS4598, Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага
- MNS5013, Бензин хөдөлгүүртэй автомашин-Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
- MNS5014, Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
- MNS5044, Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төв Ангилал. Ерөнхий шаардлага
- MNS5342, Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага
- БНБД31-03-03, Олон нийт, иргэний барилгын норматив, дүрэм
- БНБД32-04-06, Хот суурины гудамж талбайн төлөвлөлтийн норматив, дүрэм
- БНБД 30.01.04 “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”
- MNS5021, Худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага
- MNS6595, Автотээврийн салбарын ажил мэргэжлийн стандарт. Ерөнхий шаардлага
- MNS3850, Техникийн үйлчилгээ засварын систем. Нэр томъёоны тодорхойлолт
- MNS5347, Автомашины угаалгын үйлчилгээ. Ангилал, Ерөнхий шаардлага.

- MNS 6231, Тусгай зориулалтын ажлын хувцас. Ерөнхий шаардлага

4 Нэр томьёо, тодорхойлолт

4.1 Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

4.1.1 Авто үйлчилгээ

Автотээврийн хэрэгслийн техникийн байдлыг оношлох, техникийн үйлчилгээ, засвар хийх, хадгалах, тосолгооны болон ашиглалтын бусад материал худалдах, цэнэглэх, сэлбэг хэрэгсэл худалдах зэрэг автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон үйл ажиллагаа;

4.1.2 Авто үйлчилгээний байгууллага

Автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдон гарах үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэн;

4.1.3 Автотээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ

Тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаанд техникийн бүрэн байдал, найдварт ажиллагааг хангахад чиглэгдсэн бүх төрлийн техникийн үйлчилгээ, оношилгоо, засвар, угаалга зэрэг үйлчилгээ хамаарна.

4.1.4 Автотээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийн худалдаа

Тээврийн хэрэгслийн сэлбэг, хэрэгсэл, эд анги, тоног төхөөрөмж, багаж, тос, тосолгоо, тусгай шингэн болон ашиглалтын бусад материал (цаашид “бараа, бүтээгдэхүүн” гэх) худалдаалах зэрэг үйлчилгээ хамаарна.

4.1.5 Автотээврийн хэрэгсэл түүний эд анги хадгалах үйлчилгээ

Тээврийн хэрэгслийг урт, богино хугацаагаар хадгалах авто зогсоол болон түүнтэй нийцсэн бусад үйлчилгээг төлбөртэйгөөр үзүүлэхэд хамаарна.

4.1.6 Технологи

Оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын цогц;

4.1.7 Технологи ажиллагаа

Аливаа ажил, үйлчилгээний ажилбарыг техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэх тогтоосон дараалал;

4.1.8 Ажилбар

Автомашинь аль нэг агрегат, зангилаа, системийн засвар, үйлчилгээг гүйцэтгэх дэс дараалсан үйлдлийн цогц;

4.1.9 Технологийн карт

Авто үйлчилгээний технологи ажиллагаанд тулгуурласан тухайн авто үйлчилгээний ажил үйлчилгээг гүйцэтгэх ажилбар, шилжвэр, үйлдлийн дараалалд шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажлын зэрэг, хугацааг нэг бүрчлэн хүснэгтлэн жагсаасан, шаардлагатай тохиолдолд схемчлэн үзүүлсэн техникийн баримт бичиг;

4.1.10 Мэдээллийн сан

Авто үйлчилгээний байгууллага, иргэдийн хаяг байршил, хүний нөөц, үйлчилгээний онцлог, үйлчилгээний үнэ тариф, ажиллах цагийн хуваарь, үзүүлсэн үйлчилгээний талаарх өгөгдлүүдийг цаашид өргөтгөх боломжтойгоор үүсгэсэн өгөгдөл бааз;

4.1.11 Автотээврийн хэрэгслийн их бие засвар, үйлчилгээ

Автомашинь их биеийн эвдрэл гэмтлийг сэргээхтэй холбогдуулан хийх бүхий л ажилбарууд хамаарна;

4.1.12 Техникийн оношилгоо, засвар, үйлчилгээ

Тээврийн хэрэгсэл, түүний агрегат, зангилаа, системийг аливаа эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх, техникийн байдлыг оношлох, шалгах, чангалах, эд ангиудыг солих, угсрах, гэмтэл согогийг арилгах, тохируулга хийх тусгай шингэн, тос, тосолгооны болон ашиглалтын бусад материалаар цэнэглэх мөн хүрээлэн байгаа орчин, хүн амд учруулах экологийн сөрөг нөлөөг багасгахтай холбогдсон ерөнхий болон гүнзгийрүүлсэн оношилгоо, үйлчилгээ, засварын ажилбарууд хамаарна

4.1.13 Засвар үйлчилгээний ажлын дэвтэр

Тухайн автотээврийн хэрэгсэлд хийсэн засвар үйлчилгээ, түүний цаг хугацаа болон засварын баталгааг хөтөлсөн дэвтэр;

4.1.14 Цахилгаан тоноглол

Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, зорчигчийн ая тухтай байдлыг хангах цахилгаан хэрэглүүрүүдийн техникийн иж бүрдэл.

4.1.15 Техникийн шаардлага

Тухайн тээврийн хэрэгсэл, түүний агрегат, зангилаа эд ангийг засвар хийж сэргээхэд шаардлагатай нөхцөлүүдийн жагсаалт бүхий баримт бичиг. Техникийн шаардлагын дагуу автомашины засвар, үйлчилгээний сэлбэг, материалын орц, ашиглалт ба үйлчилгээний хугацаа тодорхойлогдоно. Мөн техникийн шаардлагад эд ангийн бат бэх, найдварт ажиллагаа, засвар хоорондын хугацаа зэрэг үзүүлэлтүүд хамаарна. Техникийн шаардлага нь засвар үйлчилгээний ажлын чанарыг хангах үндсэн үзүүлэлт болно.

4.1.16 Баталгаат хугацаа

Авто үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд гаргаж өгсөн хугацаа

5 Авто үйлчилгээний байгууллагын ангилал

5.1 Авто үйлчилгээний байгууллагыг ажил, үйлчилгээний төрөл, хэлбэрээс нь хамааруулж дараах байдлаар ангилна. Үүнд:

5.1.1 Автотээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ

- 5.1.1.1 Угаалга, цэвэрлэгээний үйлчилгээ
- 5.1.1.2 Техникийн оношилгоо, засвар, үйлчилгээ
- 5.1.1.3 Автотээврийн хэрэгслийн их бие засвар
- 5.1.1.4 Түлшний систем засвар, тохиргоо
- 5.1.1.5 Цахилгаан тоноглол, хэрэгслийн засвар болон цахилгаан хөдөлгүүрийн системийн засвар, тохиргоо
- 5.1.1.6 Жолооны механизм, явах ангийн засвар, тохиргоо
- 5.1.1.7 Асаалтын системийн засвар, тохиргоо
- 5.1.1.8 Хөдөлгүүр засвар
- 5.1.1.9 Хурдны хайрцгийн засвар
- 5.1.1.10 Радиатор, хөргөлт, агааржуулалтын системийн засвар
- 5.1.1.11 Резин дугуй засвар, дугуйн баланс тохируулах
- 5.1.1.12 Автомашины шил засварлах, суурилуулах
- 5.1.1.13 Ажилласан хий (утаа)-г зайлуулах систем, яндангын дуу, чимээ намсгагчын засвар, үйлчилгээ

5.1.2 Автотээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийн худалдаа

- 5.1.2.1 Сэлбэг, хэрэгслийн худалдаа
- 5.1.2.2 Тос, тосолгооны материал худалдаа
- 5.1.2.3 Оёдол, доторлогоо үйлчилгээ
- 5.1.2.4 Тээврийн хэрэгслийн резин дугуй, обуд худалдаа

5.1.3 Автотээврийн хэрэгсэл түүний эд анги хадгалах үйлчилгээ

- 5.1.3.1 Авто зогсоолын үйлчилгээ
- 5.1.3.2 Тээврийн хэрэгслийн эд анги хадгалах үйлчилгээ

6 Авто үйлчилгээний байгууллагад тавих нийтлэг шаардлага

6.1 Нутаг дэвсгэрийнхээ бүртгэх байгууллагад тогтоосон журмын дагуу бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ авсан, эрхлэх ажил, үйлчилгээний нэр төрөл, үйл ажиллагааг тодорхой заасан байхаас гадна барилга, байгууламжийг эзэмших, ашиглахтай холбогдсон баримт бичгийг зохих ёсоор бүрдүүлсэн байна.

6.2 Үйлдвэрлэл, үйлчилгээний газрын нэр, ажиллах цагийн хуваарь, холбогдох утасны дугаар бүхий самбарыг монгол хэл дээр бичиж харагдахуйц газар байршуулж, бүтээгдэхүүн, засвар үйлчилгээний үнийг нэг бүрчлэн үнэн зөв, ил тод бичсэн байх;

6.3 Эрхлэх ажил, үйлчилгээ нь хүрээлэн байгаа орчин, оршин суугчдад сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй, галын болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, хөдөлмөрийн эрүүл ахуй, тав тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх.

6.4 Техникийн аюулгүй ажиллагаа, үйлчилгээний соёл, ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын заавар, журам тогтоож мөрдүүлсэн байх.

6.5 Авто үйлчилгээ эрхлэгч нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын барилга байгууламж, зогсоол талбай, технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй байна.

6.6 Авто үйлчилгээний байгууллага нь тухайн чиглэлийн үйлчилгээнд тавих холбогдох стандарт шаардлага хангасан байна.

7 Үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламжид тавих нийтлэг шаардлага

7.1 Үйлдвэрлэл, үйлчилгээний барилга, байгууламж, түүний инженерийн шугам сүлжээ нь авто үйлчилгээний үйлдвэрлэл, үйлчилгээг явуулахад зайлшгүй шаардлагатай БНБД31-03-03 “Олон нийт, иргэний барилга”, **БНБД 30.01.04 “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”** БНБД32-04-06 “Хот суурины гудамж талбайн төлөвлөлт”-д заасан норматив шаардлагыг хангасан, агааржуулах, гэрэлтүүлэх, дулаацуулах систем, галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, тэдгээр нь хэвийн ажиллагаатай байна.

7.2 Галын аюулгүйн шаардлагыг бүрэн хангаж, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу цэвэр, бохир усны системд холбогдсон эсвэл тусгай байгууламжтай байна.

7.3 Ажилчдын хувцас солих болон амрах байр, бие засах, гар угаах газар, **үйлчлүүлэгчийн хүлээлгийн өрөө, тасалгаатай байна.**

8. Ажлын байранд тавих нийтлэг шаардлага

8.1 Ажлын байранд тухайн ажилбарыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу гаргасан ажиллах талбай, гэрэлтүүлэг, дулаацуулга, агааржуулалт, дуу чимээ, тоосжилт, чийгшил хэвийн хэмжээнд байна.

8.2 Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон галын аюулгүйн анхааруулах тэмдэг, санамжийг тавьсан байна.

8.3. Ажлын байрны гадна, дотор талыг хянах камер суурилуулсан, галын аюулгүй дохиоллоор тоногдсон байна

9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тавигдах нийтлэг шаардлага

9.1 Ажлын байранд тодорхой таних тэмдэг бүхий “Тусгай зориулалтын ажлын хувцас. Ерөнхий шаардлага” MNS 6231 : 2011 стандартын шаардлага бүрэн хангасан зориулалтын өвөл, зуны улиралд тохирсон ажлын хувцас өмсөж засвар, үйлчилгээ үзүүлнэ.

9.2 Авто үйлчилгээний байгууллага нь яаралтай тусламж үзүүлэх иж бүрдэл болон галын аюулгүй ажиллагаанд шаардагдах багаж хэрэгслээр хүрэлцэхүйц хангагдсан байна.

10 Зогсоол талбайд тавих нийтлэг шаардлага

10.1 Зогсоол талбай нь MNS 5342 : 2007стандарт, автотээврийн ажил, үйлчилгээ явуулах барилга байгууламж нь БНБД31-03-03, БНБД32-04-06 норм дүрмийн шаардлагын дагуу **автомашин тавихад зориулсан боловсронгуй төрлийн хучилттай тэгш талбай байна.**

10.2 Автотээврийн ажил үйлчилгээ явуулах барилга байгууламж БНБД31-03-03 “Олон нийт, иргэний барилга”, **БНБД 30.01.04 “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”** БНБД32-04-06 “Хот суурины гудамж талбайн төлөвлөлт”-д заасан норматив шаардлагын дагуу хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан автомашины болон явган хүний зам, **хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, зогсоол байна.**

10.3 Автотээврийн хэрэгсэл байрлах зогсоолын байрлалыг цагаан зураасаар, аюулгүйн тэмдэглэгээг шар зураасаар тэмдэглэж, зориулалтын зогсоолоос бусад газарт автотээврийн хэрэгсэл байрлуулахыг хориглоно.

11 Технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд тавих нийтлэг шаардлага

11.1 Авто үйлчилгээний байгууллага нь тухайн ажил, үйлчилгээний төрөл тус бүрт ажлын дэс дараалал, шилжвэр, үйлдлийн дараалалд шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажлын зэрэг, хугацааг нэг бүрчлэн хүснэгтлэн жагсаасан технологийн карт, боловсруулж мөрдүүлсэн байна.

11.2 Авто үйлчилгээний байгууллага нь тухайн ажил үйлчилгээний технологийн картад тусгагдсан тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр иж бүрэн тоноглогдсон байна.

11.3 Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байхаас гадна өргөх, хэмжих, хянах багаж хэрэгсэл, өндөр даралтад ажиллах тоноглол зэрэг нь тогтоосон журмын дагуу эрх бүхий байгууллагаар шалгуулж баталгаажуулсан байна.

11.4 Суурин ба зөөврийн тоноглол нэг бүрд техник ашиглалтын бүртгэлийн дэвтэр хөтөлж, аюулгүй ажиллагааны заавартай байна.

11.5 Овор жин ихтэй эд ангийг зориулалтын шаардлага хангасан тэргэнцрээр зөөвөрлөдөг байна.

12 Авто үйлчилгээний байгууллагын хүний нөөцөд тавих нийтлэг шаардлага

12.1 Авто үйлчилгээний байгууллагын захирал менежер нарын аль нэг нь Автотээврийн дээд боловсролтой, эрхэлсэн ажлынхаа чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.

12.2 Засвар, үйлчилгээ хариуцсан инженер нь автотээврийн механик-инженерийн мэргэжилтэй, эрхэлсэн ажлынхаа чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, автотээврийн хэрэгслийн техникийн байдлыг оношлох, засвар үйлчилгээ хийх талаар өндөр ур чадвар, дадлага туршлагатай, засвар, үйлчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, технологи ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техник, стандарт болон бусад баримт бичгийг судалж мэдсэн байна.

12.3 Засвар, үйлчилгээний механик нь авто тээврийн хэрэгслийн бүх төрлийн хийц загварыг оношилгооны тоног төхөөрөмж ашиглан оношлох, засварлах мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагатай, техникч-механикч мэргэжилтэй, эрхэлсэн ажлынхаа чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, засвар, үйлчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, технологи ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техник, стандарт болон бусад баримт бичгийг судалж мэдсэн байна.

12.4 Засвар, үйлчилгээний засварчин нь автотээврийн мэргэжлийн сургалтын болон авто үйлчилгээний төрөлжсөн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, засвар, үйлчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн эзэмшсэн, засварын технологи ажиллагаа, технологийн картыг судалж мэдсэн, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникт суралцаж дадлагажсан байна.

12.5 Засвар, үйлчилгээний гагнуурчин нь автотээврийн хэрэгслийн бүх төрлийн хийц загвар, агрегат, эд ангийг цахилгаан, хийн болон бусад төрлийн гагнуураар гагнах мэргэжлийн ур чадвар, дадлага туршлага эзэмшсэн, автотээврийн мэргэжлийн сургалтын болон авто үйлчилгээний төрөлжсөн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникт суралцаж дадлагажсан байна.

12.6 Автомашины сэлбэг, хэрэгсэл, тосолгооны болон ашиглалтын бусад материалын борлуулалтын ажилтан нь автотээврийн мэргэжлийн сургалтын болон авто үйлчилгээний төрөлжсөн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, борлуулж буй сэлбэг, хэрэгслийн талаар бүрэн мэдлэгтэй, үйлчлүүлэгчид мэргэжлийн зөвлөгөө өгөх чадвартай байна.

12.7 Бусад ажилчид нь Автотээврийн салбарын ажил мэргэжлийн стандарт. Ерөнхий шаардлага MNS 6595 стандартын шаардлага хангасан байна.

13. Мэдээллийн сан

13.1 Авто үйлчилгээний байгууллага нь /угаалга, цэвэрлэгээ, үйлчилгээ, оёдол, доторлогоо, моторт тээврийн хэрэгсэл, түүний эд анги хадгалах үйлчилгээнээс бусад/ мэдээллийн санд тээврийн хэрэгсэлд хийж гүйцэтгэсэн засвар, үйлчилгээ болон худалдан борлуулсан сэлбэг, хэрэгсэл, тос, тосолгоо, тусгай шингэн болон ашиглалтын бусад материалын мэдээллийг тухай бүрт үнэн зөв, бүрэн гүйцэд оруулдаг байна.

13.2 Өөрийн үйлчилгээний газрын байршил, ажиллах цагийн хуваарь, засвар, үйлчилгээний нэр төрөл, тэдгээрийн үнэ зэрэг мэдээллийг олон нийтийн мэдээллийн

хэрэгслээр нийтэд мэдээлэх, засвар, үйлчилгээ хийлгэх захиалгыг цахим сүлжээгээр хүлээн авах, хийж гүйцэтгэсэн засвар, үйлчилгээний мэдээллийг тухай бүрт нь мэдээллийн санд тэмдэглэн оруулах орчин нөхцөл бүрдүүлсэн байна.

14. Автотээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээнд тавих нэмэлт шаардлага

- 14.1. Автотээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний байгууллага нь тухайн тээврийн хэрэгслийн суудал эд анги зэргийг бохирдуулах сэвтээхээс хамгаалах бүрээс, уут сав, арчих цэвэрлэх, угаах материал хэрэглэнэ.
- 14.2. Автотээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний байгууллага нь хангалттай ажиллах агаар бүхий тусгай өрөө тасалгаанд компрессорыг байрлуулдаг байна.
- 14.3. Автотээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний байгууллага нь (авто угаалгаас бусад) үйлчилгээ, засварын ажилдаа техникийн үзүүлэлт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаад баталгаа гаргаж өгөх ба баталгааг дагалдах хуудсаар баримтжуулна.
- 14.4. Тээврийн хэрэгсэл, түүний эд ангид гагнуур хийх нөхцөлд зориулалтын хангалттай ажиллах агаар бүхий тусгай өрөө, талбайд тухайн ажилбарыг хийж гүйцэтгэнэ.

15. Угаалга, цэвэрлэгээ, үйлчилгээний байгууллагад тавих нэмэлт шаардлага.

- 15.1. Автомашин угаах зориулалттай ажлын байрны температур $+5^{\circ}\text{C}$ —ээс дээш байна.
- 15.2. Угаагч нь ус нэвтэрдэггүй малгай, бээлий, гутал, ажлын хувцсаар / аюултай ачаа тээвэрлэдэг автомашиныг угаагч нь тусгай зориулалтын хамгаалах хувцас хэрэгслээр / бүрэн хангагдсан байна.
- 15.3. Автомашин угаасан бохир усыг цэвэрлэх, зайлуулах, буцааж ашиглах зориулалтын тоног төхөөрөмж бүхий барилга байгууламжид угаах үйл ажиллагааг эрхлэн явуулна.
- 15.4. Аюултай ачаа тээвэрлэдэг автомашины угаалгын байр нь цахилгаан цэнэг саармагжуулах тоноглолыг заавал байрлуулсан байна.
- 15.5. Автомашины угаалгын үйлчилгээ. Ангилал, Ерөнхий шаардлага. MNS5347 стандартын шаардлага хангасан байна.

16. Техникийн оношилгоо, үйлчилгээний байгууллагад тавих нэмэлт шаардлага

- 16.1. Үйлчилгээ үзүүлэхдээ тээврийн хэрэгслийг техникийн шаардлагын дагуу хүлээн авсан, хүлээлгэн өгсөн тухай бүртгэл хөтлөнө.
- 16.2. Тээврийн хэрэгсэлд засвар, үйлчилгээ гүйцэтгэх бүрт тухайн тээврийн хэрэгслийн нийт явсан гүйлт, гүйцэтгэсэн ажил, зарцуулсан сэлбэг, хэрэгсэл, тос, тослогоо, тусгай шингэн болон ашиглалтын бусад материалын мэдээллийг тухай бүрт мэдээллийн санд тэмдэглэнэ.

- 16.3. Аюултай шингэн хог хаягдлыг зориулалтын бат бөх, аюултай хог хаягдалтайгаа урвалд ордоггүй саванд түр хадгалдаг байна.
- 16.4. Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх зөвшөөрөл бүхий газартай гэрээ байгуулсан байна.
- 16.5. Өргүүр болон суваг эсвэл аль алинтай нь байх ба олон суваг, өргүүртэй бол түүний тоогоор ашиглагдах багаж тоног төхөөрөмж, утаа зайлуулах төхөөрөмжтэй байна.
- 16.6. Автомашин, түүний агрегат, зангилааны техникийн байдлыг тэдгээрийг задлахгүйгээр шалгаж, оношлох тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тусламжтайгаар тодорхойлно.

17. Автотээврийн хэрэгслийн их бие засвар, үйлчилгээний байгууллагад тавих нэмэлт шаардлага.

- 17.1. Тээврийн хэрэгслийг будах +40°C халуун хатаах зориулалтын будгийн бүхээгтэй, тоосгүйжүүлэх усан хөшиг эсвэл тоосгүйжүүлэх төхөөрөмжтэй байх;
- 17.2. Гэмтэлтэй тээврийн хэрэгслийг засварын ажилд техникийн шаардлагын дагуу хүлээн авч, хүлээлгэн өгөх хуудсанд тээврийн хэрэгслийн агрегат, зангилаа их биеийн зурагнуудыг хавсарган хүлээн авна.

18. Автотээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийн худалдаанд тавих нэмэлт шаардлага

- 18.1 Худалдаа эрхлэгчид нь чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан, баталгаатай, зориулалтад тохирсон бүтээгдэхүүн борлуулж, тэдгээрийн стандартад нийцсэн үйлчилгээг үзүүлнэ.
- 18.2 Барааг худалдаалахад бэлтгэх туслах өрөө, зориулалтын талбай бүхий агуулах байна.
- 18.3 Агуулахад барааг зориулалтын тавцан дээр хананаас 20 см, халаах хэрэгслээс 1м-ээс багагүй зайд байрлуулна.
- 18.4 Худалдан борлуулах бараа, бүтээгдэхүүн нь тохирлын үнэлгээний болон гарал үүслийн гэрчилгээтэй байна.

19. Автотээврийн хэрэгсэл, түүний эд анги хадгалах үйлчилгээнд тавих нэмэлт шаардлага

19.1. Авто зогсоолын үйлчилгээ үзүүлэх байгууллага нь “Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага” MNS 5342 стандартын шаардлагад бүрэн нийцсэн байна.

19.2. Тээврийн хэрэгслийг хадгалалтад хүлээн авах, хүлээлгэн өгсөн тухай бүртгэл хөтлөх

19.3. Тээврийн хэрэгслийг хүлээн авснаас хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд тухай тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцах

ТӨГСӨВ.